

2026 он 3 сар 16 өдөр

№ 26/05

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн

ҮНДЭСЛЭХ НЬ

1. Ард Кредит ХК ББСБ нь Ариг банктай 2025 оны 02 сарын 27-ны өдөр жилийн 19.2 хувь, ашиглаагүй зээлд тооцох коммитмент хүү 4.0 хувийн хүүтэй 15 тэрбум төгрөгийн зээлийн шугамын MN950021002199000785 тоот гэрээ байгуулсан болохыг **ТЭМДЭГЛЭН**;
2. 2026 оны 03 сарын 10-ны өдрийн байдлаар дээрх гэрээний дүнгээс Ард Кредит ХК ББСБ нь 7.6 тэрбум төгрөгийг ашигласан, үлдэгдэл шугамын эрхийг ашиглах хүсэлтэй байгааг **ТЭМДЭГЛЭЖ**,

ТОГТООХ НЬ

1. Компанийн эзэмшлийн Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 19-р хороо /14083/, 4-р хэсэг гудамж 175 тоот хаягт байршилтай 1462001463 дугаар бүхий 699 м.кв га талбайтай 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууцны зориулалттай газрыг дээрх зээлд барьцаалуулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**.
2. Энэхүү тогтоолд заасан үйл ажиллагаанд холбогдох гэрээ болон бусад баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирлыг үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уянгад **ОЛГОСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ